

БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

*Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний
хэрэгжилт, үр дүн*

*Өмнөх оноос шилжиж ирсэн 3 сумын хатуу хучлттай
авто замын ажлын захиалагчийн хяналтыг цаг хугацаанд нь
хэрэгжүүлж ажилласан байна.*

АУДИТЫН КОД: БУА-2026/05-04/ШТА-НА

Булган дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор Д.Батцогт
Утас: 7034-2580 Цахим хаяг: Battsogtdb@audit.gov.mn
Аудитын менежер: Ж.Энхцоодол
Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Анхбаяр
Цахим хаяг: Ankhubayard@audit.gov.mn
Аудитор: Б.Энхтөр
Цахим хаяг: Enkhturb@audit.gov.mn

АГУУЛГА	Тайлбар	Хуудасны дугаар
Бүлэг 1	Булган аймаг Улсын төсвийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний 62 саналыг хүргүүлсэн байна.	3
Бүлэг 2	Эрх шилжиж ирсэн төсөл арга хэмжээ байхгүй байна.	4
Бүлэг 3	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа хатуу хучилттай авто замын төсөл, арга хэмжээний хэрэгжиж дуусах хугацаа болоогүй тул хүлээж авч ашиглалтад ороогүй байна.	4-7

**Аудит хийх
үндэслэл, бүрэн
эрх**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дах хэсэгт заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2025 оны 25 дугаар тогтоолд тусгасны дагуу уг аудитыг хийж гүйцэтгэв.

**Аудитын зорилго,
зорилтууд**

Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт өгч зөвлөмж боловсруулан дүнг Улсын Их Хурал болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдэнэ. Уг зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг оновчтой төлөвлөсөн эсэх;
- Төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулж хяналт тавьсан эсэх;
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь гүйцэтгүүлж төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэх.

**Аудитын хамарсан
хүрээ**

Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлсэн Төсвийн ерөнхийлөн захирагч, тэдгээрийн харьяа байгууллагууд, холбогдох бусад байгууллагыг хамруулан төсөл, арга хэмжээний төлөвлөлт, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, магадлалын ерөнхий дүгнэлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, олгосон санхүүжилт, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хамруулан аудитыг хийж гүйцэтгэсэн.

БҮЛЭГ 1. Булган аймаг Улсын төсвийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний 62 саналыг хүргүүлсэн байна.

1.1. Аймгийн хэмжээнд 16 сум, 1 тосгоноос ирсэн нийтдээ шаардлага хангасан 62 төсөл арга хэмжээг эрэмбэлэн үнэлж, холбогдох төрийн захиргааны төв байгууллагуудад цахим системээр саналыг хүргүүлсэн байна. Үүнд шинээр хэрэгжих барилга байгууламж 49, их засвар 6, тоног төхөөрөмж 5, дараа онд хэрэгжүүлэх ажлын бэлтгэл хангахад чиглэсэн ТЭЗҮ, зураг төсвийн 2 арга хэмжээг тус тус журмын дагуу төлөвлөгдсөн санал 234,895.1 сая төгрөгийн 62 төсөл, арга хэмжээг нэгтгэн Сангийн яаманд хүргүүлснээс Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн хавсралтаар батлагдсан жагсаалтад төсөл, арга хэмжээ тусгагдаагүй байна.

1.2. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд Улсын хэмжээнд болон бүсүүдэд хэрэгжүүлэх 7 төсөл, арга хэмжээнд Булган аймагт нийт төсөвт өртөг 68,318.8 сая, 2025 онд санхүүжүүлэх дүн 16,180.7 сая төгрөг тусгагдсан байна. Дээрх төсөл арга хэмжээ нь “Монгол улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”, “Монгол улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-тэй нийцсэн байна.

1.3. Өмнөх оноос үргэлжлэн хэрэгжих 22 нийт 103,626.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий төсөл арга хэмжээг 30,822.0 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

Хүснэгт 1: Төсөл арга хэмжээний ангилал

Ангилал	Шинэ TAX			Шилжих TAX			Нийт TAX		
	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тоо	Төсөвт өртөг	Санхүүж их дүн	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
Барилга байгууламж	4	66,129.0	13,990.9	20	100,205.1	30,600.6	24	166,334.1	44,591.5
Тоног төхөөрөмж	2	764.7	764.7	2	3,421.4	221.4	4	4,186.1	986.1
ТЭЗҮ	1	1,425.1	1,425.1				1	1,425.1	1,425.1
Нийт дүн	7	68,318.8	16,180.7	22	103,626.5	30,822.0	29	171,945.2	47,002.6

Эх сурвалж : Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль

Нийт санхүүжилтийн 94.9 хувийг барилга, байгууламж, 2.1 хувийг тоног төхөөрөмж, 3.0 хувийг ТЭЗҮ төсөл, арга хэмжээнд тус тус зарцуулахаар төлөвлөжээ.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжих 7 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 4 төсөл, арга хэмжээг 2025 онд, 3 төсөл, арга хэмжээг дараагийн онуудад үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ба Булган аймагт эрх шилжиж ирээгүй байна.

БҮЛЭГ 2. Эрх шилжиж ирсэн төсөл арга хэмжээ байхгүй байна.

2.1. Булган аймагт 2025 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаагүй байна.

БҮЛЭГ 3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа хатуу хучилттай авто замын төсөл, арга хэмжээний хэрэгжиж дуусах хугацаа болоогүй тул хүлээж авч ашиглалтад ороогүй байна.

3.1. Төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд хэрэгжиж байна. Булган аймгийн Гурванбулаг суманд 1.5 км, Сайхан суманд 1.7 км, Сэлэнгэ суманд 1.7 км хатуу хучилттай авто замыг 2024-2026 онд хийхээр улсын төсвийн хөрөнгө оруулалттай 5.2 тэрбум төгрөгийн өртөгтэй 2024 онд 1.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгож, 2025 онд 2.04 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгож үлдэгдэл дуусаагүй ажлын 1.8 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгоогүй байна.

3.2. Сэлэнгэ сумын 1.7 км, Гурванбулаг сумын 1.5 км хатуу хучилттай авто замын явцын хяналтыг захиалагч талаас ажил гүйцэтгэх гэрээгээр хийж сар бүр хяналтыг зургаар баримтжуулж хийж тайланг хүргүүлсэн байна. Сайхан сумын 1.7 км хатуу хучилттай авто замын хяналтыг Максимал ХХК-аар зөвлөх үйлчилгээний гэрээгээр гүйцэтгэж авто замын санхүүжилтийг 2024 онд 1.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгож, 2024-2025 онд нийт 2.04 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

3.3. Сэлэнгэ сумын 1.7 км, Гурванбулаг сумын 1.5 км хатуу хучилттай авто замын төсөл, арга хэмжээ ажлын даалгавар, техникийн тодорхойлолт, зураг төсвийн дагуу гүйцэтгүүлсэн, Сайхан сумын 1.7 км авто замын зураг зөрсөн тул хяналт хийлгэж засварлах ажлыг хийж байна.

Сэлэнгэ сумын 1.7 км хатуу хучилттай авто замын ажлыг зураг, төсвийн дагуу хийгдэж 70 орчим хувийн гүйцэтгэлтэй байна.



Гурванбулаг сумын 1.5 км хатуу хучилттай авто замын зураг, төсвийн дагуу хийгдсэн, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газраас хяналт хийгдэж 95 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байна.

хатуу хучилттай авто замыг 2024-2026 онд хийгдэхээр гэрээ байгуулж ажил гүйцэтгэх гэрээний явцын хяналтыг тухай бүрд нь хийж ажилласан байна.

3.5. Барилга байгууламжийн үе шат бүрд зохиогчийн болон захиалагчийн техникийн хяналтыг хэрэгжүүлж, акт, фото зургаар баталгаажуулж ажиллажээ. Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын 2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн Б/11 албан тушаалаар хяналтын инженертэй хөлсөөр ажиллах гэрээг байгуулж Сэлэнгэ сумын 1.7 км, Гурванбулаг сумын 1.5 км хатуу хучилттай авто замын явцын хяналтыг захиалагч талаас ажил гүйцэтгэх гэрээ хийж сар бүр хяналтыг гэрэл зургаар баримтжуулан тайланг хүргүүлсэн байна.

Булган аймгийн Засаг даргын 2024 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн А/627 захирамжаар Сайхан сумын 1.7 км хатуу хучилттай авто замын хяналтыг Максимал ХХК-аар гүйцэтгүүлэхээр зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулж гүйцэтгэж ажлын явцын техник хяналтыг хийж гэрэл зургаар баримтжуулж тайлагнасан байна.


3.6. Сэлэнгэ сумын 1.7 км хатуу хучилттай авто замын 0.8 км орчим зам нь хатуу хучилт хийгдэж гүйцэтгэл 70 орчим хувьтай байна. Явцын хяналтыг инженер У.Эрдэнэбилэгтэй хөлсөөр ажиллах гэрээ байгуулж тухай бүрд нь хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.



Гурванбулаг сумын 1.5 км хатуу хучилттай автозамын гүйцэтгэл 95 хувьтай байгаа нь замын цагаан зураас болон олон наст ургамал тарих ажил хийгдээгүй үлдсэнтэй холбоотойгоор улсын комисс хүлээж авах хугацааг хойшлуулсан байна. Явцын хяналтыг инженер У.Эрдэнэбилэгтэй хөлсөөр ажиллах гэрээ байгуулж тухай бүрд нь хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.



Сайхан сумын 1.7 км хатуу хучилтай авто замын гүйцэтгэл. Явцын хяналтыг Максимал ХХК-тай гэрээ байгуулж төлөвлөгөө гаргаж хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.



3.7. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа Сэлэнгэ сумын 1.7 км, Гурванбулаг сумын 1.5 км, Сайхан сумын 1.7 км хатуу хучилттай авто замын ажил гэрээний хугацаагаар 2026 онд хийгдэж дуусахаар гэрээ байгуулсан тул хүлээж аваагүй явцын хяналтыг тухай бүр хяналтын инженер хэрэгжүүлж ажиллаж байна.

3.8. Сэлэнгэ сумын 1.7 км, Гурванбулаг сумын 1.5 км хатуу хучилттай авто замын ажлын мэдээллийн самбарыг стандартын дагуу хийсэнд явцын хяналт хийж ажилласан ч Сайхан сумын 1.7 км хатуу хучилттай авто замын мэдээллийн самбар хийгдээгүй байна.



3.9. Сэлэнгэ сумын 1.7 км, Гурванбулаг сумын 1.5 км, Сайхан сумын 1.7 км хатуу хучилттай авто замын ажил гэрээний хугацаагаар 2026 онд хийгдэж дуусахаар гэрээ байгуулсан тул хүлээж аваагүй, бүртгэлд тусгаагүй байна.

3.10. Өмнөх аудитаар өгсөн 3 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд санал хүргүүлэхдээ шаардлага хангасан, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдуулж, төсөл, арга хэмжээний эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцож, заавар журмын дагуу эрэмбэлж саналыг ээлж дараалалтай явуулах шаардлагатай байна.
- Өмнөх оноос шилжиж хэрэгжиж буй эрх шилжиж ирсэн хөрөнгө оруулалтын 3 төсөл, арга хэмжээг хугацаанд гүйцэтгэж хуваарийн дагуу 2.7 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон, захиалагчийн техникийн хяналтыг хэрэгжүүлж цаг хугацаанд нь хэрэгжүүлж төлөвлөсөн хугацаандаа ажил хэрэгжиж байна. Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа 3 сумын хатуу хучилттай авто замын гэрээний дуусах хугацаа болоогүй тул данс бүртгэлд тусгаагүй байна.



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2026 оны 04 сарын 13 өдөр

Дугаар А/08

Булган сум

┌ Аудитын тайланг баталгаажуулах тухай ┐

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх заалт, 20 дугаар зүйлийн 20.2 дахь заалт, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18.9, Эрх шилжүүлэх тухай" 2025 оны А/175 дугаар тушаалын гуравдугаар хавсралтын 3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн"-нд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг УАГ-ын Гүйцэтгэлийн аудитын газар болон аймгийн ИТХ, Засаг даргад тус тус хүргүүлэхийг ахлах аудитор (Д.Анхбаяр)-д даалгасугай.

3. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон Булган аймаг дахь Төрийн аудитын газрын архивд хүлээлгэн өгөхийг ахлах аудитор (Д.Анхбаяр)-д үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг аудитын менежер (Ж.Энхцоодол)-д даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТЦОГТ

6326010014

